


## ДУНД БҮЛЭГ ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН АШИГЛАХ ДААЛГАВАР

Дунд бүлгийн багш нь даалгаврын өмнө үлгэрийг уншиж өгнө.

### “Баавгай ба зөгий” үлгэр

Хүн бүхэн баавгайг зөгийн балд дуртайг мэднэ. Нэг өдөр ноён баавгай шүүгээнээсээ зөгийн балаа хайгаад олсонгүй. Зөгийн бал дуусчихсан байна гэсээр ой руу явлаа. Ноён баавгай ойгоор явж байгаад зөгийн үүр оллоо. Зөгийн бал сайхан үнэртэж байсан тул шууд л зөгийн үүрийг бариад авав. Гэтэл нэг зөгий гарч ирээд: “Хөөе баавгай, яв!, энэ чиний зөгийн бал биш” гэв. Ноён баавгай дургүйцэж: “Би чамаас том, бас хүчтэй болохоор хүссэн зүйлээ хийж чадна. Одоо чимээгүй бол!” гэв. Гэтэл зөгий дүнгэнэж ирээд ноён баавгайн хамар дээр хатгаж орхив. Ноён баавгай: “Хамар минь, хамар минь. Миний уур маш их хүрч байна” гэв. Ноён баавгай урт саваа мод хайж олоод зөгийг цохих гэтэл тэр маш хурдан нисэж зугтаад байлаа. Ноён баавгайн уур бүр ч ихээр хүрч, “Би чамайг болгоод өгье л дөө. Нааш ир” хэмээн бухимдав. Гэтэл зөгий үүрэндээ орчихжээ. Ноён баавгай “Аа чи урхинд орсон доо” гээд зөгийн үүрийг цохиж гарав. Удалгүй зөгийн үүр хэдэн хэсэг болон газар уналаа. Маш олон зөгий үүрнээсээ гарч ноён баавгайг тойрон нисэв. Зөгийнүүд ноён баавгайн чих, хүзүүн дээр хатгаж араас нь хөөв. Зөгийнүүд ноён баавгайн гар, хөлөн дээр ч бас хатгав. Баавгай гүйсээр гэртээ орж ирээд хаалгаа хаалаа. Энэ бол хадагтай баавгай. Хадагтай баавгай: “Чи дахиад уураа барьж чадсангүй” гэв. Ноён баавгай: “Тийм ээ” гээд уyllлаа. Хадагтай баавгай: “Зөгийнд хатгуулсан бол энэ эмийг уух хэрэгтэй. Бас манай шүүгээнд зөгийн бал байгаа шүү дээ” гэлээ. Зөгийн бал гурилын ард байв.




Даалгаврын дугаар: 1	Бүлэг: Дунд
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Хэл яриа 2. Байгаль, нийгмийн орчин
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II	Танин мэдэхүйн түвшин: 1. Ойлгох 2. Задлан шинжлэх
Илрүүлэх чадвар: 1. Уншиж, ярьж өгсөн үлгэр, өгүүллэгийн агуулгыг ойлгох, асуултад хариулах 2. Амьтад болон эд юмсын сүүдрийг олж холбох	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай


Даалгавар	“Баавгай ба зөгий” үлгэр	
Хэрэглэгдэхүүн	“Баавгай ба зөгий” үлгэрийн цуврал зураг, дасгал ажлын хуудас	
Даалгаврын заавар	“Баавгай ба зөгий” үлгэрийн үйл явдлын тухай асуултын дагуу ярилцана. Үлгэрийн дүрүүдийн сүүдрийг олж холбоно.	
Даалгаврыг явуулах аргачлал	<b>Багшийн хэлэх үг</b>	<b>Багшийн хийх үйлдэл</b>
	<p>1. Багш нь чамаас “Баавгай ба зөгий” үлгэрийн талаар асууна. Багшийнхаа асуултыг сайн сонсоод, бодож байгаад хариулаарай.</p> <p>а. Хэн зөгийн балд дуртай вэ? (баавгай)</p> <p>б. Баавгай ой руу юу хайж явсан бэ? (зөгийн бал)</p> <p>с. Зөгий баавгайд юу гэж хэлсэн бэ? (яв, чиний зөгийн бал биш)</p> <p>д. Баавгай зөгийнд юу гэж хэлсэн бэ? (би том, хүчтэй, хүссэн зүйлээ хийнэ)</p> <p>е. Яагаад баавгай уурласан бэ? (яв гэж хэлсэн, хамар дээр нь хатгасан...)</p> <p>2. Зургийг анхааралтай ажиглаад сүүдрийг нь олж холбоорой. (баавгай, зөгий, зөгийн үүр, зөгийн балтай зөгий)</p> <p>а. Баавгайн сүүдэр нь хаана байна вэ? Зургийн хажууд байрлах цэгээс сүүдрийн хажууд байрлах цэг рүү холбоорой. (Багш энэ өгүүлбэрийг хэлэхдээ тасархай зураасын дагуу харандаагаар зааж хэлж өгнө. Ингэхдээ зурж өгөхгүй болохыг анхаарна уу.)</p>	<p>Үлгэрийг ярихдаа ашигласан цуврал зургийг хүүхдийн өмнө байрлуулсан байна.</p> <p><b>Даалгавар №1.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</b> (тусгайлан ppt хэлбэрээр өгөгдсөн бөгөөд <b>1 хувь хэвлэнэ</b>)</p> <p>Хүүхдэд дасгал ажлын хуудас өгнө. <b>Даалгавар №1.2 дугаартай үзүүлэнг ашиглана.</b></p>

<b>№1.1</b> <b>Даалгаврын үнэлгээ</b> Хэл яриа		<b>Хариултын хувилбар</b>	<b>Тохирох тэмдэглэл</b>
	1	5 асуултад хариулсан.	5
	2	4 асуултад хариулсан.	4
	3	3 асуултад хариулсан.	3
	4	2 асуултад хариулсан.	2
	5	Асуултад хариулах оролдлого хийсэн.	1
	6	Огт хариулаагүй.	0
<b>№1.2</b> <b>Даалгаврын үнэлгээ</b> Байгаль, нийгмийн орчин		<b>Хариултын хувилбар</b>	<b>Тохирох тэмдэглэл</b>
	1	4 зургийг сүүдэртэй нь холбосон.	5
	2	3 зургийг сүүдэртэй нь холбосон.	4
	3	2 зургийг сүүдэртэй нь холбосон.	3
	4	1 зургийг сүүдэртэй нь холбосон.	2
	5	Багшийн дэмжлэгтэй сүүдрийг холбосон.	1
	6	Огт оролдлого хийгээгүй	0
<b>Дэмжлэг</b>	Багш хүүхдийн яриаг дэмжиж, бодох хугацаа олгоно.		
<b>Анхаарах зүйл</b>	Сүүдрийг холбох даалгаврыг багш холбож үзүүлэхгүй, харандаагаар зааж, үгээр тайлбарлана.		

Дунд бүлэг: Хэл яриа, математикийн энгийн төсөөлөл - "Баавгай ба зөгий" үлгэр Даалгавар №1.2 (хүүхдийн тоогоор хэвлэнэ)



Хүүхдийн нэр:





Хүүхдийн нэр:

Даалгаврын дугаар: 2	Бүлэг: Дунд
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Хэл яриа 2. Математикийн энгийн төсөөлөл
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II	Танин мэдэхүйн түвшин: 1. Сэргээн санах 2. Хэрэглэх
Илрүүлэх чадвар: 1. Энгийн ба дэлгэрэнгүй өгүүлбэрээр ярих 2. Юмсын байрлалыг тодорхойлох (ард, урд, дотор, гадна)	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай

Даалгавар	“Баавгай юу, зөгий юу?”		
Хэрэглэгдэхүүн	Зурган карт (баавгай, зөгий), жижиг сагс, сандал		
Даалгаврын заавар	“Баавгай ба зөгий” үлгэрийн дүрээс сугалж, тухайн амьтны талаар ярина. Сугалсан амьтнаа дээр, доор, өмнө, хойно байрлуулна.		
Даалгаврыг явуулах аргачлал	<b>Багшийн хэлэх үг</b>	<b>Багшийн хийх үйлдэл</b>	
	<p>1. Багш нь 2 ширхэг карт доош харуулан тавьсан байна. Чи эндээс аль нэгийг нь сонгоорой.</p> <p>а. Ямар амьтан байна вэ?</p> <p>б. Үлгэрт энэ амьтан юу хийдэг билээ? Яриарай.</p> <p>2. За одоо багшийнхаа зааврыг сонсоод зөгийг (сугалсан амьтныг) заасан байрлалд тавиарай.</p> <p>а. Зөгийг сагсан дотор хийгээрэй.</p> <p>б. Зөгийг сагсны гадна талд тавиарай.</p> <p>с. Зөгийг сандлын урд тавиарай.</p> <p>д. Зөгийг сандлын ард тавиарай.</p>	<p>Амьтдын зургийг ижил хэмжээтэйгээр бэлтгэн доош харуулан тавьсан байна.</p> <p><b>Даалгавар №2.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</b></p> <p>Хүүхдийг сандлаас босгосон байна.</p> <p><b>Даалгавар №2.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</b></p>	
№2.1 Даалгаврын үнэлгээ Хэл яриа		<b>Хариултын хувилбар</b>	<b>Тохирох тэмдэглэл</b>
	1	Тухайн амьтны талаар ярихдаа 4-с дээш дэлгэрэнгүй өгүүлбэр хэлсэн.	5
	2	Тухайн амьтны талаар ярихдаа 3 дэлгэрэнгүй өгүүлбэр хэлсэн.	4
	3	Тухайн амьтны талаар ярихдаа 2 энгийн ба дэлгэрэнгүй өгүүлбэр хэлсэн.	3
	4	Тухайн амьтныг үлгэртэй холбохгүйгээр 2-с дээш онцлог шинжээр, дэлгэрэнгүй өгүүлбэрээр тайлбарласан.	2

	5	Тухайн амьтныг үлгэртэй холбохгүйгээр 2-с дээш онцлог шинжээр, энгийн өгүүлбэрээр тайлбарласан.	1
	6	Огт дуугараагүй.	0
<b>№2.2 Даалгаврын үнэлгээ Математикийн энгийн төсөөлөл</b>		<b>Хариултын хувилбар</b>	<b>Тохирох тэмдэглэл</b>
	1	Байрлал заасан 4 үгийг ойлгож байрлуулсан.	5
	2	Байрлал заасан 3 үгийг ойлгож байрлуулсан.	4
	3	Байрлал заасан 2 үгийг ойлгож байрлуулсан.	3
	4	Байрлал заасан 1 үгийг ойлгож байрлуулсан.	2
	5	Багшийн дэмжлэгтэй байрлуулсан.	1
	6	Огт үйлдэл гүйцэтгээгүй.	0
<b>Дэмжлэг</b>	Багш хүүхдэд бодох хугацаа өгч хүлээнэ.		
<b>Анхаарах зүйл</b>	Сугалсан амьтныг яриулахын тулд ямар нэгэн дэмжлэг асуулт нэмж асуухгүй. Хүүхэд өөрийн сугалсан ганц л амьтны тухай ярихыг анхаарна уу.		

Дунд бүлэг: Хэл яриа, математикийн энгийн төсөөлөл – “Баавгай юу, зөгий юу?” Даалгавар №2.1 (1 хувь хэвлэнэ)



Даалгаврын дугаар: 3	Бүлэг: Дунд
Хөгжлийн чиглэл: Бие бялдар, нийгэмшихүй	<b>Сургалтын чиглэл:</b> 1. Эрүүл мэнд 2. Нийгэмшихүй
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: II	<b>Танин мэдэхүйн түвшин:</b> 1. Хэрэглэх 2. Үнэлэх
<b>Илрүүлэх чадвар:</b> 1. Хувцсаа эвхэх үйлийг гүйцэтгэх 2. Энгийн дүрмийг ойлгож, бусдын сануулгатайгаар мөрдөх	<b>Интеграц эсэх:</b> Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай


<b>Даалгавар</b>	Тийм, үгүй	
<b>Хэрэглэгдэхүүн</b>	Богино ханцуйтай цамц (фудволк), богино өмд (шорт) “Тийм, үгүй” гэсэн сонголт бүхий зурагт хуудас	
<b>Даалгаврын заавар</b>	Богино ханцуйтай цамц, өмдийг эвхэж сандал дээр тавина. Асуултын хүрээнд “тийм, үгүй” сонголтоор хариулна.	
<b>Даалгаврыг явуулах аргачлал</b>	<b>Багшийн хэлэх үг</b>	<b>Багшийн хийх үйлдэл</b>
	<p>1. Богино ханцуйтай цамц, өмдийг эвхэж сандал дээр тавина. Эхлээд багш нь богино ханцуйтай цамц эвхэж үзүүлье.</p> <p>а. Эхлээд богино ханцуйтай цамцыг тэнийлгэж тавина.</p> <p>б. Нэг талын богино ханцуйг нугална. Нөгөө талын богино ханцуйг нугална.</p> <p>с. Хормойн хэсгээс барьж дундуур нь дээш нугална.</p> <p>2. Одоо энэ богино ханцуйтай цамцыг эвхээд сандал дээр тавиарай. Харин одоо богино өмд эвхье. Багш нь эвхэж үзүүлье.</p> <p>а. Өмдөө тэнийлгэж тавина.</p> <p>б. Өмдний нэг шуумгийг нөгөө шуумаг дээр давхарлан тавина.</p> <p>с. Өмдний доод хэсгээс авч дундуур нь нугална.</p> <p>Богино өмдийг эвхэж, сандал дээрээ тавиарай.</p> <p>2. Багш дараах 5 асуултыг асууна. Хүүхэд тийм, үгүй гэсэн тэмдэглэгээнээс тохирохыг нь заана. Энэ тэмдэглэгээ бол ТИЙМ гэсэн үг. Харин энэ тэмдэглэгээ нь ҮГҮЙ гэсэн үг шүү сайн хараад аваарай. Багшийнхаа асуултыг сонсоод бодож байгаад тийм, үгүй аль нь болохыг хэлээрэй. Жишээлбэл, Багш: Би өмдөө эвхэж тавьдаг. Тийм үү, үгүй юу? Хүүхэд: Тийм.</p>	<p>Багш урьдчилан богино ханцуйтай цамц, өмдийг бэлтгэж тавьсан байна.</p> <p><b>Даалгавар №3.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</b></p> <p>Багш хүүхдэд цамц, өмд эвхэхээс өмнө хэрхэн эвхэх дарааллыг биечлэн үзүүлнэ.</p> <p>Тийм, үгүй гэсэн тэмдэглэгээг хүүхдийн өмнө байрлуулсан байна.</p> <p><b>Даалгавар №3.2 дугаартай үзүүлэнг ашиглана.</b></p>





	<p>Багш нь одоо чамаас асуулт асууя. Чи харин бодож байгаад тийм, үгүй гэсэн хариултын аль нэгийг зааж хэлээрэй.</p> <p>a. Би цэцэрлэгтээ орж ирээд багштайгаа мэндэлдэг. Тийм үү, үгүй юу? (тийм)</p> <p>b. Би гаднаас орж ирээд гутлаа арчдаг. Тийм үү, үгүй юу? (тийм)</p> <p>c. Би гутлаа зэрэгцүүлж тавьдаг. Тийм үү, үгүй юу? (тийм)</p> <p>d. Би ангидаа гадуур гуталтайгаа явдаг. Тийм үү, үгүй юу? (үгүй)</p> <p>e. Би цэцэрлэгтээ ирээд хоолойгоо зайлдаг. Тийм үү, үгүй юу? (тийм)</p>		
<p><b>№3.1</b> Даалгаврын үнэлгээ Эрүүл мэнд</p>		<b>Хариултын хувилбар</b>	<b>Тохирох тэмдэглэл</b>
	1	Бие даан богино ханцуйтай цамц болон өмдийг эвхэж, эмх цэгцтэй тавьсан.	5
	2	Бие даан богино ханцуйтай цамц болон өмдийг эвхсэн ч эмх цэгцгүй тавьсан.	4
	3	Богино ханцуйтай цамц болон өмдний аль нэгийг эвхэж, эмх цэгцтэй тавьсан.	3
	4	Багшийн дэмжлэгтэй богино ханцуйтай цамц, өмдийг эвхэж тавьсан.	2
	5	Өгөгдсөн хувцсыг бөөрөнхийлж тавьсан.	1
	6	Огт үйлдэл хийгээгүй.	0
<p><b>№3.2</b> Даалгаврын үнэлгээ Нийгэмшихүй</p>		<b>Хариултын хувилбар</b>	<b>Тохирох тэмдэглэл</b>
	1	5 асуултад тохирох тэмдгийг сонгож харуулсан.	5
	2	4 асуултад тохирох тэмдгийг сонгож харуулсан.	4
	3	3 асуултад тохирох тэмдгийг сонгож харуулсан.	3
	4	2 асуултад тохирох тэмдгийг сонгож харуулсан.	2
	5	1 асуултад тохирох тэмдгийг сонгож харуулсан.	1
	6	Огт хариулаагүй.	0
<b>Дэмжлэг</b>	Багш хүүхдэд богино ханцуйтай цамц болон богино өмдийг нэг удаа эвхэж харуулна.		
<b>Анхаарах зүйл</b>	Богино ханцуйтай цамц, богино өмд эвхэх аргачлалыг багш ашиглах бөгөөд хүүхдэд харуулах шаардлагагүй.		



Дунд бүлэг: Эрүүл мэнд, Нийгэмшихүй – “Тийм, үгүй” Даалгавар №3.2 (1 хувь хэвлэнэ)



Дунд бүлэг: Эрүүл мэнд, Нийгэмшихүй – “Цамц эвхэх аргачлал” Даалгавар №3.1  
(1 хувь хэвлэнэ)




<b>Даалгаврын дугаар:</b> 4	<b>Бүлэг:</b> Дунд
<b>Хөгжлийн чиглэл:</b> Танин мэдэхүй	<b>Сургалтын чиглэл:</b> 1. Дүрслэх урлаг 2. Математикийн энгийн төсөөлөл
<b>Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин:</b> II	<b>Танин мэдэхүйн түвшин:</b> 1. Бүтээх 2. Ойлгох
<b>Илрүүлэх чадвар:</b> 1. Тосон харандаагаар зурж дүрслэх 2. Тодорхой тооны эд зүйлээс нэг нэгээр хорогдуулж, нэмэгдүүлж, дүн тоог хэлэх	<b>Интеграц эсэх:</b> Тийм
<b>Даалгаврыг гүйцэтгэх хугацаа:</b> Хүүхдийн гүйцэтгэлээр	<b>Даалгаврын хэлбэр:</b> Задгай

<b>Даалгавар</b>	Баавгайн толгойг зураарай.	
<b>Хэрэглэгдэхүүн</b>	Баавгайн толгойн бэлдэц зураг, тосон харандаа, зөгий-6ш	
<b>Даалгаврын заавар</b>	Баавгайн чих, нүд, ам, хамар зэргийг дүрслэн зурна. Ширээн дээрх 6 ширхэг зөгийнөөс нэг нэгээр хорогдуулж, нэмэгдүүлж, дүн тоог хэлнэ.	
<b>Даалгаврыг явуулах аргачлал</b>	<b>Багшийн хэлэх үг</b>	<b>Багшийн хийх үйлдэл</b>
	<p>1. Хүүхдэд баавгайн толгойн бэлдэц зураг бүхий цаасыг өгч чих, нүд, хамар, ам зэргийг зуруулна.</p> <p>a. Энэ дугуй дүрсийг ашиглан баавгайн толгой зурна.</p> <p>b. Баавгайн чих, нүд, хамар, амыг зураарай. (Энэ өгүүлбэрийг нэг л удаа хэлэх бөгөөд нүд зураарай, одоо хамар зураарай гэж нэг бүрчлэн хэлэхгүй)</p> <p>2. Ширээн дээрх зөгийн зургаас багшийнхаа хэлсэн тоогоор аваарай.</p> <p>a. Зөгийн зургаас 1 ширхэгийг аваарай. Ширээн дээр хэдэн зөгий үлдсэн бэ? (5)</p> <p>b. Эдгээр зургаас дахиад 1 ширхэг зөгий аваарай. Ширээн дээр хэдэн зөгий үлдсэн бэ? (4)</p> <p>c. Дахиад 1 ширхэг зөгий аваарай. Ширээн дээр хэдэн зөгий үлдсэн бэ? (3)</p> <p>d. Эдгээр зураг дээр 1 ширхэг зөгий нэмж тавиарай. Хэдэн зөгий болсон бэ? (4)</p> <p>e. Эдгээр зураг дээр дахиад 1 ширхэг зөгий нэмж тавиарай. Хэдэн зөгий болсон бэ? (5)</p>	<p>Баавгайн толгойг гүйцээж зурах цаасны ард хүүхдийн нэрийг бичнэ.</p> <p><b>Даалгавар №4.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</b></p> <p>Хүүхдийн өмнө ширээн дээр 6 ширхэг зөгийн зураг тавьсан байна.</p> <p><b>Даалгавар №4.2 дугаартай үзүүлэнг ашиглана.</b></p>
	<b>Хариултын хувилбар</b>	
	<b>Тохирох тэмдэглэл</b>	

<b>№4.1</b> <b>Даалгаврын үнэлгээ</b> Дүрслэх урлаг	1	Харандааг зөв барьж, баавгайн чих, нүд, хамар, амыг зөв байрлуулж зурсан.	5
	2	Харандааг зөв барьж, чих, нүд, ам, хамраас 3-г нь дүрслэн зурсан.	4
	3	Харандааг буруу барьж, чих, нүд, хамар, амыг дүрслэн зурсан.	3
	4	Харандааг буруу барьж, чих, нүд, ам, хамраас 3-г нь дүрслэн зурсан.	2
	5	Багшийн дэмжлэгтэй чих, нүд, хамар, ам дүрслэн зурсан.	1
	6	Огт үйл гүйцэтгээгүй.	0
<b>№4.2</b> <b>Даалгаврын үнэлгээ</b> Математикийн энгийн төсөөлөл		<b>Хариултын хувилбар</b>	<b>Тохирох тэмдэглэл</b>
	1	5 даалгаврыг гүйцэтгэж, дүн тоог хэлсэн.	5
	2	4 даалгаврыг гүйцэтгэж, дүн тоог хэлсэн.	4
	3	3 даалгаврыг гүйцэтгэж, дүн тоог хэлсэн.	3
	4	2 даалгаврыг гүйцэтгэж, дүн тоог хэлсэн.	2
	5	1 даалгаврыг гүйцэтгэж, дүн тоог хэлсэн.	1
6	Огт дуугараагүй.	0	
<b>Дэмжлэг</b>	Хүүхдэд үйл хийх боломж олгож хүлээнэ.		
<b>Анхаарах зүйл</b>	Хүүхэд ширээн дээрх 6 ширхэг зөгийнөөс хэлсэн тоогоор хорогдуулж, нэмэгдүүлээд ширээн дээр үлдсэн зөгийг тоолж хэлнэ. Баавгайг дүрслэн зурсан цаасны ард хүүхдийн нэрийг бичнэ.		

**Дунд бүлэг: Дүрслэх урлаг, Математикийн энгийн төсөөлөл**


**“Баавгайн толгойг зураарай” Даалгавар №4.1 (1 нүүрийг 2 хүүхдээр тооцож хэвлэнэ)**



Хүүхдэд тасархай зураасын дагуу хайчилж өгнө үү.

Дунд бүлэг: Дүрслэх урлаг, Математикийн энгийн төсөөлөл

Даалгавар №4.2 (1 хувь хэвлэнэ)



Зөгийн зургийг хайчилж тараах материал болгон ашиглана уу.